



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон нутгийн өмчийн газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/088/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2025 он

Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: М.Энхжаргал

Утас:70432545 Цахим хаяг: enkhjargalm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.ЭНХБАЯР ТАНАА

2025.02.25 № 2/64

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын захирамжаар Орон нутгийн өмчийн газрын хөрөнгөд бүртгэлтэй 7,138,736.9 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 59,904.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 32 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлт 85.0 хувьтай үнэлэгдсэн байна .

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,373,884.00</u>	<u>6,013,297.37</u>
33	АВЛАГА	278,505.00	410,918.37
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	278,505.00	410,918.37
35	БАРАА МАТЕРИАЛ	4,095,379.00	5,602,379.00
354	Хангамжийн материал	4,095,379.00	5,602,379.00
35410	Бичиг хэргийн материал	670,100.00	1,367,400.00
35420	Аж ахуйн материал	3,165,279.00	3,974,979.00
35470	Бусад хангамжийн материал	260,000.00	260,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,182,716,884.28</u>	<u>3,672,258,875.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,182,716,884.28	3,672,258,875.54
392	Биет хөрөнгө	5,182,716,884.32	3,672,258,875.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,589,103,491.00	4,682,753,197.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(6,649,780,506.49)	(1,078,935,479.71)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	94,770,000.00	94,770,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(94,770,000.00)	(94,770,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	225,839,918.00	248,734,568.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	(197,793,042.33)	(199,866,413.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,445,029.00	32,910,362.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,009,743.86)	(13,407,359.13)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1,211,841,739.00	-
39217	Ном	70,000.00	70,000.00
393	Биет бус хөрөнгө	(0.04)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	457,000.00	457,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(457,000.04)	(457,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,187,090,768.28</u>	<u>3,678,272,172.91</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>610,168.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	610,168.00
4136	Бусад өглөг	-	610,168.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	610,168.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,187,090,768.28</u>	<u>3,677,662,004.91</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,187,090,768.28	3,677,662,004.91
512	Хуримтлагдсан үр дүн	5,187,090,768.28	3,677,662,004.91
51210	Өмнөх үеийн үр дүн	5,187,090,768.28	5,187,090,768.28
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,509,428,763.37)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,187,090,768.28</u>	<u>3,678,272,172.91</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	506,924,272.71	684,607,698.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	52,342,974.99

Орон нутгийн өмчийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

120	Нийтлэг татварын бус орлого	-	52,342,974.99
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	52,342,974.99
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	52,342,974.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	506,924,272.71	632,264,723.28
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	171,426,172.71	235,584,123.28
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,387,832.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	30,601,280.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	167,038,340.71	204,754,030.28
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	228,813.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	335,498,100.00	396,680,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	335,498,100.00	396,680,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,177,258,464.01	862,840,224.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,177,258,464.01	862,840,224.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	997,435,681.72	628,234,563.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,649,902.02	294,167,266.84
210101	Үндсэн цалин	111,257,025.02	166,385,918.00
210102	Нэмэгдэл	65,418,867.00	92,091,853.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,116,000.00	10,883,188.00
210104	Урамшуулал	10,654,600.00	24,806,307.00
210105	Гэрээт ажлын хөлс	37,203,410.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,368,637.40	34,680,963.00
210201	Тэтгэврийн даатгал	20,167,792.97	20,156,326.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,374,600.69	5,771,636.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,868,880.48	2,334,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	434,444.68	1,206,213.20
210205	Эрүүл мэндийн даатгал	4,522,918.58	5,212,586.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,000,000.00	22,000,000.00
210302	Түлш, халаалт	20,000,000.00	22,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,889,294.00	23,400,586.63
210401	Бичиг хэрэг	3,974,706.00	3,850,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,092,588.00	13,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,777,800.00	2,093,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	55,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	989,200.00	1,123,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	2,774,386.63
2107	Томилолт, зочны зардал	10,000,000.00	18,600,000.00
210702	Дотоод албан томилолт	10,000,000.00	18,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,965,038.00	3,071,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,514,990.00	-

Орон нутгийн өмчийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	176,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	174,048.00	441,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,100,000.00	1,575,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	677,562,810.30	232,314,746.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	710,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	108,270.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	677,454,540.30	231,604,746.84
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	179,822,782.29	234,605,661.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,319,200.00	29,495,280.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,809,200.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	26,151,280.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,510,000.00	3,344,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,346,141.58	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,346,141.58	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	155,157,440.71	205,110,381.44
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	155,157,440.71	205,110,381.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(670,334,191.30)	(178,232,526.48)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,331,196,236.89
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,331,196,236.89
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,331,196,236.89)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(670,334,191.30)	(1,509,428,763.37)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	506,924,272.71	632,264,723.28
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	506,924,272.71	632,264,723.28
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	171,426,172.71	235,584,123.28
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,387,832.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	30,601,280.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	167,038,340.71	204,754,030.28
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		228,813.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	335,498,100.00	396,680,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	335,498,100.00	396,680,600.00

Орон нутгийн өмчийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	506,924,272.71	632,264,723.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	506,924,272.71	632,264,723.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	327,101,490.42	397,659,061.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,716,937.65	293,557,098.84
210101	Үндсэн цалин	114,831,563.11	166,385,918.00
210102	Нэмэгдэл	84,903,374.54	91,481,685.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,082,000.00	10,883,188.00
210104	Урамшуулал	-	24,806,307.00
210105	Гэрээт ажлын хөлс	26,900,000.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,384,950.77	34,680,963.00
210201	Тэтгэврийн даатгал	20,184,106.33	20,156,326.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,374,600.70	5,771,636.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,868,880.48	2,334,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	475,800.00	1,206,213.20
210205	Эрүүл мэндийн даатгал	4,481,563.26	5,212,586.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,000,000.00	22,000,000.00
210302	Түлш, халаалт	20,000,000.00	22,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,234,700.00	22,018,700.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	5,368,700.00
210402	Тээвэр, шатахуун	7,968,500.00	13,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,192,030.00	2,080,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	70,170.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,004,000.00	1,010,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,000,000.00	18,600,000.00
210702	Дотоод албан томилолт	10,000,000.00	18,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,325,732.00	3,071,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,764,732.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	176,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	175,000.00	455,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,100,000.00	2,100,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	110,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	439,170.00	3,731,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,098,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	439,170.00	633,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	179,822,782.29	234,605,661.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,319,200.00	29,495,280.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,809,200.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	26,151,280.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,510,000.00	3,344,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,346,141.58	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,346,141.58	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	155,157,440.71	205,110,381.44
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	155,157,440.71	205,110,381.44
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		

Орон нутгийн өмчийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

/төгрөгөөр/

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,187,090,768.28		5,187,090,768.28
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,187,090,768.28		5,187,090,768.28
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,187,090,768.28		5,187,090,768.28
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			
D08	Тайлант үеийн үр дүн		(1,509,428,763.37)	(1,509,223,763.37)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,187,090,768.28	(1,509,428,763.37)	3,677,662,004.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	396680600.00	396553061.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	396680600.00	396553061.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	393248600.00	393209061.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	291767200.00	293557098.84
210101	Үндсэн цалин	162076400.00	166,385,918.00
210102	Нэмэгдэл	104077600.00	91,481,685.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13860000.00	10,883,188.00
210104	Урамшуулал	11753200.00	24,806,307.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36470900.00	34680963.00
210201	Тэтгэврийн даатгал	24800200.00	20,156,326.64
210202	Тэтгэмжийн даатгал	2917700.00	5,771,636.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	2334200.00	2,334,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	583500.00	1,206,213.20
210205	Эрүүл мэндийн даатгал	5835300.00	5,212,586.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22000000.00	22000000.00
210302	Түлш, халаалт	22000000.00	22000000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19412500.00	19568700.00
210401	Бичиг хэрэг	4760000.00	4918700.00
210402	Тээвэр, шатахуун	11500000.00	11500000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,080,000.00	2,080,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	72,500.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,010,000.00
2107	Томиллолт, зочны зардал	18,600,000.00	18,600,000.00
210702	Дотоод албан томиллолт	18,600,000.00	18,600,000.00

Орон нутгийн өмчийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,098,000.00	3,071,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	480,000.00	455,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	300,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	68,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	2,100,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900,000.00	1,731,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,100,000.00	1,098,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	633,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,432,000.00	3,344,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,432,000.00	3,344,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,432,000.00	3,344,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	396,680,600.00	396,553,061.84
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	396,680,600.00	396,553,061.84
132001	Орон нутгийн төсвөөс	396,680,600.00	396,553,061.84
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12.00	12.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	12.00	12.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8.00	8.00
650004	Төрийн мэргэжлийн алаан хаагч (ТҮМ)	3.00	3.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.00	1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,268,732.00	30,601,280.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,268,732.00	30,601,280.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,268,732.00	4,450,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,387,832.00	2,450,000.00
210401	Бичиг хэрэг		450,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,387,832.00	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,880,900.00	2,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,880,900.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		26,151,280.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		26,151,280.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,268,732.00	30,601,280.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,268,732.00	30,601,280.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,387,832.00	26,380,093.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,880,900.00	4,221,187.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 212,530.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 206,045.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹ -г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлсэн 204,982.8 мянган төгрөгийн тохируулах бичилт хийгээгүй
- Цалин болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,062.7 мянган төгрөгөөр зөрүүлэн тайлагнасан

Залруулагдаагүй 6,485.0 мянган төгрөгийн 4 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 6,485.0 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн өмчийг түрээслэх гэрээ байгуулсан боловч гэрээний хэрэгжилтийг тооцоогүйгээс түрээсийн орлогыг дутуу оруулсан зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн төлбөрийг бүрэн, цаг хугацаанд нь оруулж, байгууллагын дотоод хяналт хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг тооцох

3.1.2 Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Албан хаагчдаас авах насжилт өндөртэй авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх"; гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагыг 2025 оны эхний хагас жилд багтаан барагдуулах

3.1.3 Цалин урамшуулалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын тамгын газрын даргын 2/1865 тоот албан бичиг болон Засаг даргын 2024 оны Б/40 тоот захирамжийг үндэслэн ажилчдад мөнгөн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", ЗГ-ын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна"; гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ЗГ-ын тогтоолын дагуу улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хянах олгож байх.

3.1.4 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, дараа жилийн төсвийн /зорилтот түвшин/ төсөл, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал /Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт/ мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь хангалтгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; 6.4.1.тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт; гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг үнэн зөв байршуулан Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.